



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Гадаад арга хэмжээнд оролцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. Бразил Улсын Рио де Жанейро хотод 2016 онд зохион байгуулагдах “Рио-2016” Зуны олимпын зохион байгуулах хорооны удирдлагатай албан уулзалт хийх, хамтын ажиллагааны гэрээ байгуулах, олимпын хотхоны үйл ажиллагаатай танилцах зорилгоор Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн захирал Д.Жаргалсайханыг 2016 оны 03 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд албан томилолтоор ажиллахыг зөвшөөрсүгэй.
2. Арга хэмжээнд оролцох удирдамжийг хавсралтаар баталж, ажлын тайланг ирсэн өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан танилцуулахыг Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн захирал (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.
3. Дээрх хугацаанд төвийн захирлын албан үүргийг тус төвийн Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ж.Ундрахбилэгээр түр орлон гүйцэтгүүлсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга (Б.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080225

Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 03 дугаар сарын 04.-ны өдрийн 08. тоот тушаалын хавсралт

**“РИО-2016” ОЛИМП, ПАРАЛИМПИЙН НААДМЫН
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ
ТАНИЛЦАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Бразил Улсын Рио де Жанейро хотноо 2016 оны 03 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд “Рио-2016” Олимп, Паралимпийн наадмын зохион байгуулах хорооны үйл ажиллагаатай танилцах, Монголын баг тамирчдын Олимп, паралимпийн наадмын өмнөх бэлтгэх хийх бэлтгэлийн төвүүдтэй танилцах, албан уулзалт хийж гэрээ байгуулах.

Хоёр.Хугацаа

2016 оны 03 дугаар сарын 13-18-нд.

Гурав. Арга хэмжээ болох газар

Бразил улсын Рио де Жанейро хот.

Дөрөв. Ажиллах чиглэл

- “Рио-2016” Олимп, Паралимпийн наадмын Зохион байгуулах хорооны үйл ажиллагаатай танилцах;
- “Рио-2016” олимп, паралимпийн наадам зохиогдох барилга байгууламжтай танилцах;
- Монголын Үндэсний шигшээ баг тамирчдын олимпийн өмнөх бэлтгэл хийх бэлтгэлийн төвүүдтэй танилцах;
- Спортын байгууламжийг ашиглах талаар холбогдох удирдлагуудтай албан ёсны уулзалт хийж, гэрээ байгуулах;